

Бурхан бол Ялгуусан

Дэлхийн Мацаг барих ба Залбирлын Өдөр—2022 оны 1-р сарын 12

Магтаал—Бурхан бол бидний хүч чадал: хүсэл зориг, зан чанар, оюун ухаан, зорилготой, хүчийг эсэргүүцэх хүчтэй нэгэн.

Дуулал 93:1 Эзэн захирдаг. Тэрээр сүр жавхлангаар хувцасласан юм. Эзэн Өөрийгөө **хүч чадлаар** хувцаслаж, бүсэлсэн. Үнэхээр дэлхий бат бөх тогтсон бөгөөд ганхахгүй.

1 Шастир 16:27 Түүнд яруу алдар ба сүр жавхлан бий. Түүний газарт **хүч чадал**, баяр баясгалан бий.

Дуулал 68:28 Чиний Бурхан чамд хүчийг тушаав. Бидэнд үйлдэж байсан Бурхан, Та **хүчээ** харуулаач.

Дуулал 138:3 Дуудсан өдөрт минь Та надад хариулав. Сэтгэлийг минь **хүч чадлаар** зоригжуулав.

Гэмшил

Ингэснээр Эзэн Есүс маань бүх ариун хүнтэйгээ хамт ирэхэд бидний Бурхан бөгөөд Эцэгийн өмнө Тэр та нарын зүрхийг ариун чанар дор гэм зэмгүй гэж батална. Амен. **1 Тесалоник 3:13**

Талархал

Харин би **хүч чадлыг** тань дуулна. Өглөөгүүр хайр энэрлийг тань Баяр хөөртэйгөөр дуулна. Учир нь зовлон шаналлын минь өдөр Миний бат цайз, Хоргодох газар минь байсаар ирсэн. **Дуулал 59:16**

Зуучлан залбирах

Бидний хүүхдүүд

Тэр чи Бурхан Эзэнээ бүх зүрх, бүх сэтгэл, бүх **хүч**, бүх оюун ухаанаараа хайрла. Мөн хөршөө өөрийн адил хайрла гэв. **Лук 10:28**

Итгэгч сургуулийн сурагч/багш/ажилчид

ЭЗЭНийг хийгээд Түүний **хүч чадлыг** эрэлхийлэгтүн. Түүний нүүр царайг үргэлж хайгтүн. **Дуулал 105:4**

Үл итгэгч сургуулийн сурагч/багш/ажилчид

Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно. **Ром 10:9**

Сургуулийн төлөө санаа тавих

Ард түмнүүдийн ургууд аа, Эзэнд өргөгтүн, Эзэнд яруу алдар, **хүч чадлыг** өргөгтүн. **1 Шас 16:28** сүнсний сэргэлт, библийн хэмжүүр, өндөр ёс суртахуунаар удирдуулах, хамгаалалт болон бусад зүйл

Ээжүүд Хамтдаа Залбирах нь байгууллагын төлөө санаа тавих

Хүч чадал минь ээ, Би Таныг магтан дуулна. Учир нь Бурхан, миний бат цайз Надад энэрэл хайраа үзүүлдэг Бурхан. **Дуулал 59:17, Филлипой 4:13**

Ерөөл

Бидний Эзэн Есүс Христ Өөрөө мөн биднийг хайрлаж, мөнх тайтгарал ба сайн найдварыг нигүүлсээр өгсөн Эцэг Бурхан маань та нарын зүрхийг аливаа сайн үйл хийгээд үг дотор тайтгаруулж, бататгах болтугай. **2 Тесалоник 2:16-17, 3:5**

